

“СТАНДАРТ БА ХӨГЖИЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Бүтээгдэхүүн, үйлчилгээ тогтоосон стандарт, шаардлагыг хангаж байгааг нотлоход шаардлагатай стандартчилал, хэмжил зүй (шинжлэх ухаан, аж үйлдвэрийн, хууль эрх зүйн), итгэмжлэл, тохирлын үнэлгээ (хяналт шалгалт, сорилт, бүтээгдэхүүн болон тогтолцооны баталгаажуулалт) зэрэг нь чанарын дэд бүтцийг бүрдүүлдэг бөгөөд манай улсын хувьд үндэсний чанарын дэд бүтцийг олон улсын шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

Хөгжингүй орнуудын хувьд зах зээлд нийлүүлж байгаа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал хангагдсан эсэхийг тухайн бүтээгдэхүүнд холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага, тохирлын үнэлгээ, хяналтын механизмын тогтолцоог харгалзан тодорхойлдог бөгөөд эдгээрийн үндсэн дээр худалдааны гэрээ, хэлцэл байгуулж байна.

Үндэсний чанарын дэд бүтцийн эрх зүйн орчныг цаашид олон улсын жишигт хүргэж боловсронгуй болгох замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Стандарт ба хөгжил үндэсний зорилтот хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

Хөтөлбөр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэх бөгөөд Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050”-д тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болно.

1.2 Хөтөлбөрийн алсын хараа

Чанарын дэд бүтцийг Олон Улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгосны үндсэн дээр экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчны болон хүнсний аюулгүй байдлыг хамгаалан иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн салбарын хүний нөөцийг бүрдүүлэн чадавхжуулж, бэхжүүлнэ.

2.1.1. Мэдлэг, ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх;

- 2.1.1.1. Гадаад, дотоодын их дээд сургуульд бакалавр, магистр, докторт хамруулахад дэмжлэг үзүүлэх;
- 2.1.1.2. Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн тэргүүлэх мэргэжлийн жагсаалтад “хэмжил зүйн инженерчлэл”-ийг оруулах;
- 2.1.1.3. Боловсролын тогтолцоонд стандартчилал, хэмжил зүйн мэргэжлийн индекс/кодчиллыг оруулах;
- 2.1.1.4. Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний талаарх мэдлэг ойлголтыг бүх шатны боловсролын хөтөлбөрт тусгах, хэрэгжүүлэх;
- 2.1.1.5. Чанарын дэд бүтцэд оролцогч байгууллага хүний нөөцийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хангалттай ажилтан, албан хаагчийг бүрдүүлэх;

2.1.2. Хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх;

- 2.1.2.1. Мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах нөхцөлийг сайжруулах;
- 2.1.2.2. Ажилтнуудыг олон улсын болон гадаадын ижил түвшний байгууллагын сургалт, мэргэжилтэн солилцох хөтөлбөрт хамруулах;
- 2.1.2.3. Зөвлөх үйлчилгээний тогтолцоог бий болгох, салбарын мэргэшсэн байгууллагын үйл ажиллагааг дэмжих;
- 2.1.2.4. Хэмжил зүй, тохирлын болон итгэмжлэлийн үнэлгээний мэргэжилтнийг чадавхжуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний ажилтныг бий болгохыг дэмжих;
- 2.1.2.5. Албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн уян хатан, үр дүнтэй тогтолцоог сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2.1.3. Чанарын дэд бүтцийн сургалтын тогтолцоо, чадавхыг нэмэгдүүлэх;

- 2.1.3.1. Сургалтын байгууллагыг өргөжүүлэн бэхжүүлж, чадамжинд суурилсан сургалтын тогтолцоог боловсронгуй болгох;
- 2.1.3.2. Чанарын дэд бүтцийн салбарт сургагч багш нарыг бэлтгэх, хөгжлийг дэмжих;
- 2.1.3.3. Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд төр хувийн хэвшлийн олон талт хамтын ажиллагааг дэмжих;

2.2. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

2.2.1. Стандартчилал, хэмжил зүйн салбарын хуулийг шинэчлэх;

- 2.2.1.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулах;
- 2.2.1.2. Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулах;
- 2.2.1.3. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулан батлуулах;
- 2.2.1.4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулан батлуулах;
- 2.2.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний

жагсаалт", "Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам"-ыг тус тус шинэчлэн батлуулах;

- 2.2.1.6. Салбарын хуульд уялдуулан холбогдох эрх зүйн баримт бичгийг шинэчлэн, хэрэгжилтийг хангуулах;
- 2.2.1.7. Эрх зүйн баримт бичгийг бодлогын баримт бичиг, олон улс, бүс нутгийн байгууллагын стратеги, баримт бичиг, гэрээ хэлэлцээрт нийцүүлэх;

2.3. Стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн түвшин бүрэн хэрэгжсэн байна.

2.3.1. Стандартын шинжлэх ухаан, техникийн түвшинг дээшлүүлэх;

- 2.3.1.1. Стандартчилалын төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжүүлэлтэд талуудын оролцоог нэмэгдүүлэх;
- 2.3.1.2. Стандартын үзлэг хийж стандарт боловсруулах, дахин хянах, хүчингүй болгох ажлыг чанарын өндөр түвшинд зохион байгуулах;
- 2.3.1.3. Олон улс болон гадаад орны стандартыг үндэсний болгон нутагшуулах;

2.3.2. Стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулах;

- 2.3.2.1. Стандартыг хэрэгжүүлэхэд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
- 2.3.2.2. Чанарын дэд бүтцийн талаар мэдээлэл, сурталчилгааны ажлыг өрнүүлж, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх;
- 2.3.2.3. Стандартын хэрэгжилтэд тохирлын үнэлгээний байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;
- 2.3.2.4. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд сонирхогч талуудад дэмжлэг үзүүлэх;
- 2.3.2.5. Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангах үүргийг бүрэн хариуцах тогтолцоог хэвшүүлэх;
- 2.3.2.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй ногоон технологийг нэвтрүүлэх;
- 2.3.2.7. Экспортын тэргүүлэх салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;
- 2.3.2.8. Импортыг орлох бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.3.3. Техникийн зохицуулалтыг боловсруулж мөрдүүлэх;

- 2.3.3.1. Аюулгүй байдалтай холбоотой асуудлаар техникийн зохицуулалтыг боловсруулах ажлыг эрчимжүүлэх;
- 2.3.3.2. Баталсан техникийн зохицуулалтыг мөрдүүлэх (техникийн зохицуулалтад стандартыг эш татах) ажлыг зохион байгуулах;

2.4. Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн тогтолцоог Олон Улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ.

- 2.4.1. Чанарын дэд бүтцийн зохион байгуулалтыг Олон Улсын жишигт нийцүүлэн оновчтой болгож сайжруулах;

- 2.4.1.1. Салбарын бүтцийг оновчтой зохион байгуулж, мэргэжлийн байгууллагыг дэмжих, бүсчлэн хөгжүүлэх;
- 2.4.1.2. Хэмжил зүйн болон стандартчиллын судалгаа шинжилгээний хүрээлэн байгуулах, хөгжүүлэх;
- 2.4.1.3. Хэмжил зүй, сорилт туршилтын мэргэжлийн байгууллага, лабораториудыг шинээр бий болгох, чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх;
- 2.4.1.4. Итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох, итгэмжлэлийн хамтын ажиллагааны олон улсын байгууллагаас гаргасан тохирлын үнэлгээний баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих;
- 2.4.1.5. Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйг хөгжүүлэх санхүүжилтийн тогтолцоог бий болгох, сан байгуулж хөгжүүлэх;

2.4.2. Мэргэжлийн байгууллагыг бий болгож хөгжүүлэх;

- 2.4.2.1. Тохирлын үнэлгээний салбарын байгууллагыг бий болгох, чадавхыг дээшлүүлэх;
- 2.4.2.2. Хэмжил зүйн зарим ажил үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн мэргэшсэн байгууллагуудаар гүйцэтгүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;
- 2.4.2.3. Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний чиглэлийн төрийн бус байгууллагуудыг нэмэгдүүлж, хамтран ажиллах;
- 2.4.2.4. Зах зээлийн хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;

2.4.3. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

- 2.4.3.1. Олон улс, бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- 2.4.3.2. Олон улсын байгууллагын гишүүнчлэл, үйл ажиллагааны статусаа нэмэгдүүлэх;
- 2.4.3.3. Гадаад улс орны чанарын дэд бүтцийн байгууллагуудтай техникийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
- 2.4.3.4. Эталоны хэмжил, шалгалт тохируулгын үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх;
- 2.4.3.5. Тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, хэлэлцээрт нэгдсэн хүрээг өргөжүүлэх;
- 2.4.3.6. Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах үйл ажиллагаанд хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага /OIML CS/-ийн тогтолцоог нэвтрүүлэх;
- 2.4.3.7. Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд бүх талын оролцоог хангуулах;

2.5. Стандартчилал, хэмжил зүйн салбарын дэд бүтэц, техникийн чадавхыг нэмэгдүүлнэ.

2.5.1. Хэмжил зүйн салбарын техникийн чадавхыг нэмэгдүүлэх;

- 2.5.1.1. Хэмжлийн Улсын ба анхдагч эталоныг олон улсын жишгийн дагуу шинээр болон шинэчлэн бий болгож, хөгжүүлэх, хэмжил зүйн нэгж дамжуулалтыг хангах; /шинээр: хүч, чичиргээ, гэрэлтүүлэг, хатуулга, эргүүлэх хүчний момент, статик даралт, акустик, соронзон, радио давтамж/, /шинэчлэх: цаг, урт, масс, цахилгаан, даралт, нягт, зарцуулалт, эзлэхүүн, температур/
- 2.5.1.2. Хэмжил зүйн байгууллагын ажлын эталоны техникийн чадавхыг бэхжүүлэх;
- 2.5.1.3. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын ажил үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах;
- 2.5.1.4. Хэмжил зүйн олон улсын харьцуулалтад оролцох, үндэсний лаборатори хоорондын харьцуулалт зохион байгуулах;
- 2.5.1.5. Тохирлын үнэлгээний баталгаажуулалтын байгууллагын техникийн чадавхыг дээшлүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх;
- 2.5.1.6. Сорьцын хяналтын лабораторийн техникийн чадавхыг нэмэгдүүлэх;
- 2.5.1.7. Хэмжил зүйг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- 2.5.1.8. Хэмжлийн улсын эталон, стандартчилсан загварыг хөгжүүлэх талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг их дээд сургуулиудтай хамтран зохион байгуулах, инновац, шинэ санааг дэмжих;

2.5.2 Сорилт туршилтын чадавхыг сайжруулах;

- 2.5.1.1. Стандартчилсан загвар, уусмалыг шинээр бий болгох, үйлдвэрлэх, аттестатчилах, хөгжүүлэх;
- 2.5.1.2. Үйлдвэрлэлийн хэмжил зүйн нэгж дамжуулалтын тасралтгүй байдлыг хангах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 2.5.1.3. Ур чадварын сорилтод оролцох, үндэсний лаборатори хоорондын харьцуулалт зохион байгуулах;

2.5.3. Хэмжил зүйн болон сорьцын лабораторийг бэхжүүлэх;

- 2.5.3.1. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын шалгалт тохируулга, баталгаажуулалтын лабораторийг шинээр байгуулах, хөгжүүлэх;
- 2.5.3.2. Сорьцын хяналтын салбар лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлэх, Үнэт металлын сорьц тогтоох, Эрдэнийн чулууны лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх;
- 2.5.3.3. Хэмжил зүйн хүрээлэнгийн зориулалт бүхий шинэ барилга, байгууламжтай болох;

2.5.4. Стандартын нэгдсэн сан, сургалтын баазыг бэхжүүлэх;

- 2.5.4.1. Стандартын нэгдсэн сангийн хадгалалт хамгаалалтын сайжруулах чиглэсэн дэд бүтцийг бүрдүүлэх;
- 2.5.4.2. Сургалтын орчин нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүний баазыг нэмэгдүүлэх;

2.6. Чанарын дэд бүтцийн үйл ажиллагааны цахимжуулалтыг эрчимжүүлж, дижитал шилжилтийг нэвтрүүлнэ.

2.6.1. Технологи, инновацад суурилсан цахимжуулалтыг хөгжүүлэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шат дамжлагыг бууруулах, иргэн төвтэй төрийн удирдлагын дэвшилтэт тогтолцоог бүрдүүлэх;

2.6.1.1. Чанарын дэд бүтцийн үйлчилгээг үйл ажиллагааг цахимжуулах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээ үзүүлэх;

2.6.1.2. Чанарын дэд бүтцийн оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, аюулгүй байдлыг хангах;

2.6.1.3. Гадаад худалдааны цахим хяналтын тогтолцоог бүрдүүлж, экспортын бүтээгдэхүүний гэрчилгээ, мэдэгдлийг цахим хэлбэрээр олгох, мэдээ мэдээлэл, бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэх;

2.6.1.4. Цахимжуулалтын техникийн бааз, программ хангамжийг нэмэгдүүлэх;

2.6.2. Чанарын дэд бүтцийн үйл ажиллагаанд дижитал технологийг дэмжиж нэвтрүүлж эхлэх;

2.6.2.1. Дижиталчлалыг нэвтрүүлэх, хөгжүүлэх чиглэлээр цахим хөгжлийн асуудал хариуцсан төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургуулиуд, мэдээлэл технологийн паркттай хамтран ажиллах;

2.6.2.2. Дижиталчлалын талаар олон улсын туршлага судлах, хүний нөөцийг чадавхжуулах;

2.6.2.3. Дижиталчлалыг /дижитал шалгалт тохируулгын гэрчилгээг/ нэвтрүүлэх стратеги, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

3.1.1. Чанарын дэд бүтцийг дэлхий нийтийн жишиг, хөгжлийн чиг хандлагад тулгуурлан Монгол Улсын хөгжлийн онцлогийг харгалзан хөгжүүлэх;

3.1.2. Экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг тэргүүн ээлжид дэмжих;

3.1.3. Төр, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлан олон нийтийн оролцоог хангах;

3.1.4. Чанарын дэд бүтэц дэх оролцогч талуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

3.1.5. Аюулгүй байдал болон эрүүл ахуй, ариун цэвэр, чанарын стандартыг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэхийг дэмжих;

3.1.6. Чанар, стандартын шаардлага хангаагүй бол бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэхийг хориглох хүртэл арга хэмжээг авах;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2023-2032 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн үр дүн

- 5.1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин сайжирна.
- 5.2. Амьдрах орчин, чанар сайжирна.
- 5.3. Олон нийтийн стандартын талаарх мэдлэг, ойлголт дээшилсэн байна.
- 5.4. Стандартын хэрэгжилтийн түвшнийг ахиулна.
- 5.5. Хэмжлийн нэгдмэл байдал улсын хэмжээнд хангагдах нөхцөл бүрдэнэ.
- 5.6. Үндэсний стандартыг олон улсын стандартад нийцүүлнэ.
- 5.7. Үндэсний бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх, гадаад зах зээлд гаргах боломж бий болно.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

- 6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
- 6.2. Улсын болон орон нутгийн төсөв;
- 6.3. Шинжлэх ухаан, технологийн сан;
- 6.4. Олон Улсын байгууллага, гадаад улсаас олгосон зээл, тусламж;
- 6.5. бусад;

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1 Захиргааны байгууллага нь (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжилтийн тайланг гаргаж Засгийн газрын тогтоолоор баталсан *“бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д* заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

--- о О о ---